

**Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл
(MERESP)
Төслийн дугаар# P174116**

АЖЛЫН ДААЛГАВАР

eJob платформд шинээр оруулсан ажил мэргэжлүүдийн ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолтыг боловсруулахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд дэмжлэг үзүүлэх дотоодын зөвлөх хуулийн этгээд

Үндэслэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” нь хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан ажиллагчдад түр хугацаанд хөнгөлөлт үзүүлэх зорилготой. Төсөл нь дараах үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн хэсэг 1: Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагуудтай нягт хамтран ажилласнаар ажил олгогч болон ажил хайгчдад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг 2: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 3: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цар хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 4: Зохих шалгуур хангасан ажиллагч, ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийг түр хугацаагаар хөнгөлөх.

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд дараах үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

(a) Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээнд үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (b) **Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем (LMIS) болон мэдээллийн технологийн дэвшилтэд технологид суурилсан ажил зуучлалын үйлчилгээг нэвтрүүлэх**

(c) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын мэдээллийн систем, сургалтын орчныг сайжруулж, байр/танхимыг засварлан тохижуулах; (d) Техникийн туслалцаа, боловсон хүчнийг сургах замаар төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх.

ХНХЯ хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлж “eJob”-платформыг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Платформ нь 3 дэд систем, 13 модулиас бүрдсэн ба онлайн портал болон гар утасны аппликейшнтэй. Одоогийн байдлаар ажлын байрны захиалга өгөх, өөрийн анкетаа системд оруулж ажил хайгчаар бүртгүүлэх, ажлын байрны мэдээлэл авч ажилд зуучлуулах боломжтой болсон.

Системээр ажилд зуучлахдаа ажлын байрны захиалга, ажил хайгчийн анкетын нийцлийг олон шалгуурыг харгалзан үзэж, оноогоор үнэлдэг. Тиймээс ажил зуучлалын үйлчилгээнд ашиглаж байгаа YAMAT-08 буюу Үндэсний ажил

мэргэжлийн ангилал, тодорхойлолтын индекс/код, ур чадвар, ажлын байрны тодорхойлолт зэрэг иж бүрэн мэдээлэл “eJob” платформд шаардлагатай байна.

Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт нь нийт 10 үндсэн бүлэгтэй, индекс/код үүсгэсэн 4218 ажил, мэргэжлийн жагсаалт байгаа боловч зарим ажил, мэргэжлээр ажлын байрны гүйцэтгэх чиг үүрэг, тодорхойлолт гаргаагүйгээс хэрэглээ, ойлголтын зөрүү гарч байна.

Түүнчлэн мэдээллийн системээр дамжуулан ажлын байранд зуучлах эсвэл нийцлийг тодорхойлоход зарим ажил мэргэжил (6 оронтой код бүхий) байхгүй нь үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй байдаг. Иймд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд ХНХЯ-д дэмжлэг үзүүлэх “ejob” платформын ажил зуучлалын үйлчилгээнд ашиглах YAMAT-08-д шинээр ажил мэргэжил оруулах үндэсний зөвлөхийг ажиллуулсан. ХНХЯ Үндэсний зөвлөхийн боловсруулсан ажил зуучлалын үйлчилгээнд түгээмэл ашиглаж буй 65 ажил, мэргэжлийг YAMAT-08-д нэмж оруулсан.

Энэ арга хэмжээний үр дүнд 4 орон бүхий индекс/кодтой ажил мэргэжлийг 6 оронтой болгон шинэчилж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/143 тоот тушаалаар батлуулсан. Мөн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээг сайжруулах, ажилд зуучлахад шаардагдах 75 ур чадварын багц (мэдлэг, хандлага, ур чадвар)-ыг “eJob” платформд оруулан ашиглаж байна.

Дээрхээс үндэслэн YAMAT-08-д шинээр оруулсан 65 ажил, мэргэжлийн ажил мэргэжлийн товч болон дэлгэрэнгүй тодорхойлолт, гүйцэтгэх чиг үүрэг, ажлын жишээг боловсруулах шаардлагатай байна.

Тиймээс ХНХЯ “eJob” платформ болон YAMAT-08-д шинээр оруулсан 65 ажил, мэргэжлийн ажлын байрны товч болон дэлгэрэнгүй тодорхойлолтыг боловсруулж ажил, мэргэжил бүрээр гүйцэтгэх чиг үүргийг боловсруулах үндэсний зөвлөх байгууллага ажиллуулахаар энэхүү ажлын даалгаврыг боловсруулав.

<p>Үйл ажиллагааны хамрах хүрээ</p>	<p>Даалгавар 1. Ажил, мэргэжлийн товч болон дэлгэрэнгүй тодорхойлолтыг боловсруулах.</p> <ol style="list-style-type: none"> 1. Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08)-д шинээр нэмж оруулсан 65 ажил, мэргэжлүүдийн (үндсэн бүлэг, дэд бүлэг, бага бүлэг, нэгж бүлэг тус бүрийн чиг үүрэг, болон YAMAT-08-д оруулах бусад тодорхойлолт) гүйцэтгэх чиг үүргийг багтаасан ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолтыг боловсруулах (ХНХЯ-ны Сайдын 2022 оны А/143 дугаар тушаал); 2. Тухайн ажил, мэргэжил тус бүр дээр жишээ гаргах; 3. Боловсруулсан ажил, мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолт, ажил, мэргэжлийн жишээ болон бусад шаардлагатай тодорхойлолтыг тухайн ажил, мэргэжлийн салбарын мэргэжлийн холбоо, мэргэжилтнүүдээр хэлэлцүүлж, саналыг тусган ХНХЯ-ны Сайдаар батлуулахаар эцэслэх. <p>Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа хамгийн сүүлийн үеийн эх сурвалж, мэдээлэл болон олон улсын туршлага, ялангуяа европын ажил, мэргэжлийн ангилал боловсруулсан туршлагыг анхаарч үзэх шаардлагатай.</p> <p>Даалгавар 2. Мэдээллийн сан үүсгэж, ажлын цар хүрээний дагуу тэдгээрийг ангилахад ХНХЯ-д техникийн туслалцаа үзүүлэх.</p> <ol style="list-style-type: none"> 1. ХНХЯ болон ХХҮЕГ-ын шаардлага/техникийн тодорхойлолтын дагуу холбогдох мэдээллийн санд мэдээлэл байршуулахад дэмжлэг үзүүлнэ. Цахим систем www.yamat.mlsp.gov.mn; болон www.ejob.gov.mn-ын индекс/кодын ангилалд “Тодорхойлолт”, “Чиг үүрэг” “Ажил мэргэжлийн дэд бүлэг тус бүрийн жишээ” гэсэн цэсийг шинээр нэмж, цахим системд нэмэлт мэдээлэл оруулахад дэмжлэг үзүүлэх; 2. Бүх материалыг ХНХЯ-д (Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (ХХБХЗГ), Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (ХЭБХЗГ)) болон Төслийн нэгжид хэвлэмэл хэлбэрээр болон файлаар хүлээлгэн өгнө. 3. ХНХЯ-ны Сайдын тушаалаар батлагдсаны дараа www.yamat.mlsp.gov.mn болон www.ejob.gov.mn цахим системд мэдээллийг оруулахад дэмжлэг үзүүлэх;
--	--

<p>Нийлүүлэх бүтээгдэхүүн</p>	<p>Нийлүүлэх бүтээгдэхүүн 1: Батлагдсан ажлын нарийвчилсан төлөвлөгөөг 2023 оны 06-р сарын 23-ны дотор ирүүлэх. Ажлын төлөвлөгөөг ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын дарга болон ХХБХЗГ-ын дарга батална.</p> <p>Нийлүүлэх бүтээгдэхүүн 2: 2023 оны 08-р сарын 01-ний дотор 65 ажил, мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг ирүүлэх (ажил мэргэжил тус бүр дээрх жишээ багтана)</p> <p>Нийлүүлэх бүтээгдэхүүн 3: 2023 оны 08 дугаар сарын 31-ний дотор ХНХЯ-ын сайдын тушаалаар батлагдсан баримт бичгийн дагуу www.yamat.mlsp.gov.mn болон www.ejob.gov.mn цахим системд засвар өөрчлөлтийг хийхэд ХНХЯ-нд дэмжлэг үзүүлсэн тухай тайлан.</p>
<p>Шаардагдах ур чадвар, туршлага</p>	<p>Зөвлөх баг 3-аас доошгүй мэргэжлийн гишүүнтэй байна. Зөвлөх багийн мэргэжлийн гишүүд дараах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, үндэсний ажил мэргэжлийн ангилал, ажлын байрны тодорхойлолт, ур чадвар хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх түвшинд хамгийн багадаа 5 жилийн ажлын туршлагатай байх; 2. Ажил, мэргэжил, мэргэжлийн ангилал, ажил үүрэг, шаардлагуудын талаар нарийн мэдлэг/туршлагатай байх; 3. Зөвлөх баг нь хөдөлмөрийн эдийн засаг, хүний нөөц болон бусад холбогдох чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй 2 гишүүнтэй байх; 4. Багийн гишүүд үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг боловсруулж байсан туршлагатай бол давуу тал болно; 5. Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
<p>Явцын тайлан, үр дүнг хянах</p>	<p>Зөвлөх байгууллага нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдлага дор ажиллана. Зөвлөхийн үйл ажиллагааг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал; - Нийлүүлэх үр дүнг заасан хугацаанд гүйцэтгэсэн байдал; - Гүйцэтгэсэн ажлын чанар;
<p>Хугацаа</p>	<p>Зөвлөх компани нь гэрээ байгуулснаас хойш 4 сарын хугацаанд уг зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.</p>

Тайлагналт болон төлбөр	<p>Зөвлөх үйлчилгээний нийт төсөв 117.000.000 төгрөгөөс хэтрэхгүй байна.</p> <p>Төлбөрийг дараах байдлаар 3 хувааж төлнө:</p> <ul style="list-style-type: none">-Хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн 1-ийн ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 10%-Хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн 2-ын ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 70%-Хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн 3-ын ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 20%
------------------------------------	---